



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2022 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/335

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2, 9.1.7, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2022 оны 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батлан хамгаалахын сайдын нэрэмжит “Шинжлэх ухаан, технологийн шилдэг бүтээл шалгаруулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөл (Б.Баярмагнай), Зэвсэгт хүчний Жанжин штаб (дэслэгч генерал Д.Ганзориг), Үндэсний батлан хамгаалахын их сургууль (бригадын генерал П.Жаргалан), Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн (хурандаа Б.Эрдэнэбат), Цэргийн төв эмнэлэг (хурандаа Б.Энх-Од), Батлан хамгаалахын төв архив (дэд хурандаа Ж.Гантулга), Монгол цэргийн музей (хурандаа Д.Ганзориг)-д тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (хурандаа Б.Эрхэмбаяр)-т даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Батлан хамгаалахын сайдын 2017 оны “Журам батлах тухай” А/335 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Г.САЙХАНБАЯР

1322190579

Батлан хамгаалахын сайдын 2022 оны
09 дүгээр сарын 08-ны өдрийн
А/240 дугаар тушаалын хавсралт



БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН НЭРЭМЖИТ ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ШИЛДЭГ БҮТЭЭЛ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Улс орныг батлан хамгаалах үйл ажиллагаанд шинжлэх ухаан, технологи, инновацын үр дүнг нэвтрүүлэх, түүний хөгжлийг дэмжих, эрдэм шинжилгээний ажилтнуудын идэвх, санаачилгыг өрнүүлэх, оюуны чадавх, мэдлэгийг арвижуулах, шилдэг бүтээлүүдийг шалгаруулах, тэдгээрийг сурталчлах зорилгоор Батлан хамгаалахын сайдын нэрэмжит “Шинжлэх ухаан, технологийн шилдэг бүтээл”-ийг жил бүр шалгаруулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. “Шинжлэх ухаан, технологийн шилдэг бүтээл”-ийн оны шагналыг Монгол Улсын “Шинжлэх ухааны ажилтны өдөр”-өөр гардуулна.

1.3. Шинжлэх ухаан, технологийн шилдэг бүтээлийг дараах 9 төрлөөр шалгаруулна:

- 1.3.1. аюулгүй байдал, батлан хамгаалах судлал;
- 1.3.2. цэргийн ухаан;
- 1.3.3. цэргийн түүх судлал;
- 1.3.4. цэргийн зэвсэглэл;
- 1.3.5. цэргийн техник;
- 1.3.6. цэргийн инновацын дэвшил;
- 1.3.7. цэргийн технологийн дэвшил;
- 1.3.8. 35 хүртэлх насны залуу судлаачийн бүтээл;
- 1.3.9. шинэ бүтээл, оновчтой саналын бүтээл.

1.4. Шалгарсан бүтээлийн төрөл тус бүрд “Шинжлэх ухаан, технологийн шилдэг бүтээл”-ийн өргөмжлөл, мөнгөн урамшуулал, бусад шагнал олгоно.

1.5. Шилдэг бүтээлийн шалгаруулалтад нэр дэвшүүлэх тухай зарыг тухайн жилийн 8 дугаар сард багтаан хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар дамжуулан улс орон даяар нээлттэйгээр нийтэд зарлана.

1.6. Шалгаруулалтад эрдэм шинжилгээний байгууллага, аж ахуйн нэгж, судлаачид, эрдэмтдийн хамтлаг, хувь хүмүүс шинжлэх ухааны бүтээлээ дэвшүүлж болно.

1.7. Шалгаруулалтад судлаачдын сүүлийн 4 жилийн дотор туурвисан бүтээлийг дэвшүүлнэ.

1.8. Шилдэг бүтээлийг шалгаруулах үйл ажиллагааны зардал болон шилдэг бүтээлд олгох өргөмжлөл, мөнгөн шагналыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад жил бүр тусган санхүүжүүлнэ.

Хоёр. Шалгаруулалтад нэр дэвшүүлэх бүтээлд тавигдах шаардлага

2.1. Эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээ, судалгаа, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон, улс орноо батлан хамгаалах эрх ашиг, цэргийн шинэчлэлд дорвитой хувь нэмэр оруулсан аюулгүй байдал, батлан хамгаалахын болон цэргийн шинжлэх ухааны онол, урлаг, арга зүйн ном, нэг сэдэвт бүтээл (монограф⁷) болон инновац, технологийн дэвшлийг тусгасан, зэвсэглэл, техникийн зохион бүтээгдсэн ажил, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зориулан гаргасан бүтээлийг шалгаруулалтад оруулна.

2.2. Шалгаруулалтад ирүүлэх бүтээл дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.2.1. Патентын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11⁸ дэх заалт, мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.2⁹ дахь хэсэгт заасан шинэ бүтээлийн түвшинг агуулсан, патент, зохиогчийн эрх авсан байх;

2.2.2. бүтээлийн шинжлэх ухаан, технологид оруулж буй хувь нэмэр, ач холбогдолтой байх;

2.2.3. тухайн бүтээлийг хэвлэн нийтлүүлсэн болон үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байдал, гарсан үр дүнтэй байх;

2.2.4. шинэ санаа, тэргүүний технологийг түгээн дэлгэрүүлэх инновацийн чиг хандлагатай байх,

2.2.5 цэргийн техник, технологи, инновацийн дэвшлийг агуулсан байх;

2.2.6. шинээр олдсон түүх, соёлын ховор нандин дурсгал, эд өлгийн зүйлс, ховор олдворын тухай эрдэм шинжилгээний ажлын үр дүнгээр хийсэн бүтээл, тайлан байж болно.

2.3. Хамтын бүтээлийг нэр дэвшүүлэхдээ зохиогчийн хамтлаг нь 5 хүнээс хэтрэхгүй байна. Хэрэв зохиогчийн хамтлаг 5 хүнээс илүү байх тохиолдолд уг бүтээлийг бий болгоход гишүүн бүрийн оруулсан бодит хувь нэмэр, оролцоог дэвшүүлж буй байгууллагын Эрдмийн зөвлөл эсхүл хамтын олны хурлын нууц санал хураалт явуулж, олонхын санал авсан дарааллаар зохиогчдыг нэр дэвшүүлнэ.

2.4. Хамтын бүтээлийн зохиогчдын бүрэлдэхүүн, оролцоог нэр дэвшигч бүхэн хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан байна.

⁷ Шинжлэх ухааны тодорхой салбарын нэг чиглэлээр судлаач эрдэмтэн өөрийн хэвлэн нийтлүүлсэн эрдэм шинжилгээний үр дүнг үндэс болгон бусад эрдэмтдийн судалгааны үр дүнтэй харьцуулан нэгтгэж, асуудлыг тал бүрээс авч үзэж, шийдэгдсэн ба шийдэгдээгүй (нээлттэй) асуудлууд, тэдгээрийн онол-практикийн ач холбогдлыг харуулсан бүтээлийг монограф гэж үзнэ. Эл шаардлагыг хангаагүй бол "ном" гэсэн ангилалд хамааруулна.

⁸ "Патентын тухай" хууль. 3.1.11."патент" гэж тухайн шийдэл нь шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар болохыг тодорхойлж, патент эзэмшигч нь тодорхой хугацаанд энэ хуулийн 46.2-т заасан онцгой эрхийг эдлэх эрхийг;

⁹ "Патентын тухай" хууль. 5.2.Техникийн өмнөх түвшинд хамааруулна: 5.2.1.шинэ бүтээлийн анхдагч огноо, эсхүл давамгайлах огнооноос өмнө нөхцөлийг техникийн өмнөх түвшинд хамааруулна: 5.2.1.шинэ бүтээлийн анхдагч огноо, эсхүл давамгайлах огнооноос өмнө амаар, бичгээр, эсхүл бусад хэлбэрээр Монгол Улсад болон гадаад улсад нийтлэгдсэн, хэрэглэгдэж ирсэн, эсхүл нийтэд илэрхий болсон шийдэл, эсхүл мэдлэг; 5.2.2.шинэ бүтээлийн анхдагч огнооноос өмнө, эсхүл давамгайлах огнооноос өмнө бусад этгээдийн Монгол Улсад мэдүүлсэн, албан ёсны тогтмол хэвлэлд нийтлэгдсэн, патент олгогдсон шинэ бүтээл, ашигтай загвар.

2.5. Бүтээлийг бий болгоход захиргааны буюу зохион байгуулалтын ажил эрхэлж байсан хүнийг зохиогчийн хамтлагийн бүрэлдэхүүнд оруулахгүй.

2.6. Эрдмийн зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл, орчуулсан ном, сурах бичиг, гарын авлага, улсын захиалгат шинжлэх ухаан, технологийн төсөл, гадаадын хамтарсан төсөл, захиалгат даалгаварт судалгааны ажлын үр дүнгээр бүтээгдсэн болон төсвийн хөрөнгөөр хийгдсэн бүтээлийг шалгаруулалтад хүлээн авахгүй.

Гурав. Шилдэг бүтээлийн шалгаруулалтад ирүүлэх материалын бүрдүүлэлт

3.1. Батлан хамгаалахын сайдын нэрэмжит шилдэг бүтээлийн шалгаруулалтад нэр дэвшүүлэх бүтээлийн талаар Эрдмийн зөвлөл (Сургалт-аргазүйн зөвлөл¹⁰)-ийн хурлаар нээлттэй, ил тод хэлэлцэх ба олонх дэмжсэн тохиолдолд тухайн бүтээлийг дэвшүүлнэ.

3.2. Шилдэг бүтээлийн шалгаруулалтад ирүүлэх материалууд:

3.2.1. шалгаруулалтад оролцуулах бүтээлийн хэвлэн нийтлэгдсэн эх, зохион бүтээгдсэн бие анги;

3.2.2. цэргийн зэвсэглэл, техник, инновацын дэвшил бүтээлд техникийн зураг, технологийн карт, технологийг ашигласны эдийн засгийн үр ашгийн тооцоог хавсаргасан байна. Үүнд:

3.2.2.1. технологийн үнэ (борлуулалтын өртөг);

3.2.2.2. үйлдвэрлэлийн зардал;

3.2.2.3. бүтээгдэхүүний өөрийн өртөг;

3.2.2.4. үйлдвэрлэлийн орлого;

3.2.2.5. үйлдвэрлэлийн цэвэр ашиг;

3.2.2.6. өртгөө нөхөх хугацаа;

3.2.2.7. тухайн технологиор үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний чанарын түвшин, стандарт, зах зээл, аюулгүй байдал, технологийн боловсронгуй байдал (ашиглагдаж буй технологиудын дотор шинэ ба шинэчлэгдсэн дэвшилтэт технологийн эзлэх хувийн жин,

3.2.2.8. материалын ашиглалт (хаягдлын үзүүлэлт);

3.2.2.9. тухайн технологийн онцлогтой холбогдох бусад хүчин зүйл, үзүүлэлт зэрэг болно.

3.2.3. бүтээлийн танилцуулга (Үүнд: зохиогч /хамтран зохиогч/-ийн нэр, аюулгүй байдал, батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухааны онол, аргагүй болон зэвсэглэл, техник, технологийн шийдэлд оруулж буй хувь нэмэр, шинэлэг тал, үр ашиг, өгөөж, техник-эдийн засгийн үндэслэл болон үр ашгийн тооцоо);

3.2.4. уг бүтээлийг шүүн хэлэлцээд Батлан хамгаалахын сайдын нэрэмжит оны шилдэг бүтээлийн шалгаруулалтад дэвшүүлж буй Зэвсэгт хүчний Жанжин штабын Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөл, сургууль, эрдэм

¹⁰ Дээд боловсролын тухай хууль.11 дүгээр зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагын удирдлага. 11.4.Сургалт-эрдэм шинжилгээний ажлын чиглэлийг тогтоож, түүний онол, арга зүйн түвшин, ач холбогдол, үр дүнг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах зорилгоор их сургууль, дээд сургуульд эрдмийн зөвлөл, коллежид сургалт-арга зүйн зөвлөл ажиллана.

шинжилгээ, судалгааны байгууллагын албан бичиг, Эрдмийн зөвлөл (Сургалт-аргазүйн зөвлөл)-ийн хурлын тэмдэглэл;

3.2.5. уг бүтээлийг цэргийн хэрэг, үйлдвэрлэлд туршиж, нэвтрүүлсэн тухай байгууллагын тодорхойлолт;

3.2.6. уг бүтээлд тухайн мэргэжлийн 2-оос доошгүй эрдэмтний дүгнэлт, шүүмж байна;

3.2.7. шалгаруулалтад ирүүлж буй бүтээлийн оюуны өмчийн гэрчилгээ, патент¹¹, ашигтай загварын болон зохиогчийн эрхийн гэрчилгээг хавсаргана. Хэрэв байхгүй тохиолдолд тухайн бүтээлийг шалгаруулалтад оруулахгүй.

3.3. Нууцын зэрэгтэй бүтээлийг нэр дэвшүүлсэн тохиолдолд бүрдүүлсэн материалд нууцын тэмдэг дарсан байна.

3.4. Бүтээлийн шалгаруулалтад ирүүлэх материалын бүрдэлт дутуу буюу хугацаа хэтэрсэн тохиолдолд бүтээлийг хүлээн авахгүй.

3.5. Өмнө нь төр, засгийн болон үндэсний хэмжээний албан ёсны шагнал, шалгаруулалтад шалгарч байсан бүтээлийг хүлээн авч, давхардуулан шалгаруулахгүй.

3.6 Шалгаруулалтад зохиогч 1-ээс илүүгүй бүтээлийг ирүүлнэ. Хамтын бүтээлд оролцсон бол 1-ээс илүүгүй байна.

Дөрөв. Шилдэг бүтээлийг хүлээн авах, шалгаруулах

4.1. Шалгаруулалтад нэр дэвшүүлж, энэ журмын 2 дугаар бүлгийн шаардлагыг хангасан 3 дугаар бүлэгт заасны дагуу бүрдүүлсэн материал, баримт бичгийг зохиогч болон түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүлээн авна.

4.2. Зэвсэгт хүчний анги, байгууллагуудаас ирүүлсэн бүтээлийг Зэвсэгт хүчний Жанжин штабын Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөл шалгаруулсан байна.

4.3. Тухайн жилд шалгаруулалтад ирүүлж буй бүтээлээс хамаарч Батлан хамгаалахын сайдын тушаалаар шалгаруулах комиссыг томилно.

4.4. Комисс нь үйл ажиллагаандаа “Шинжлэх ухаан, технологийн тухай”, “Патентын тухай”, “Оюуны өмчийн тухай”, “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиуд болон Засгийн газрын 2007 оны 147 дугаар тогтоолоор батлагдсан “Шинжлэх ухаан, технологийн шагнал олгох журам” болон Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/141 дүгээр тушаалаар батлагдсан “Эрдэм

¹¹ “Патентын тухай” хуулийн 22 дугаар зүйл. Улсын нууцад холбогдох шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар. 22.1.Үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах үйл ажиллагаанд хамаарах онц чухал, маш нууц, нууц зэрэглэлд хамаарах шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг тагнуулын төв байгууллагад бүртгүүлсний дараа Оюуны өмчийн газрын ерөнхий шинжээч хүлээн авч, нууц бүтээлд хайлт, шүүлт хийх эрх бүхий шинжээчид шилжүүлэн дүгнэлт гаргуулж, патент олгох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулж, урамшуулах журам"-д нийцүүлэн гаргасан энэхүү журмыг дагаж мөрдөнө.

4.5. Комисс нь чиглэл тус бүрээр 5 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд тэдний 2/3 (гуравны хоёр) нь цэргийн эрдэмтэд, бусад нь тухайн чиглэлийн тэргүүлэх мэргэжилтэн байна. Комиссын бүрэлдэхүүнд бүтээл нь нэр дэвшсэн эрдэмтэн, судлаач оролцохгүй.

4.6. Комиссын гишүүд шалгаруулалтад ирүүлсэн материалтай нэг бүрчлэн танилцаад дараах үзүүлэлтээр үнэлгээ (оноо)-г нууцаар өгнө. Үүнд:

4.6.1. хэвлэмэл (Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал, Цэргийн ухаан, Цэргийн түүх судлал, Цэргийн зэвсэглэл, Цэргийн техник, Цэргийн инновацын дэвшил, Цэргийн технологийн дэвшил) шилдэг бүтээлийг дүгнэх үзүүлэлт:

№	Үзүүлэлт	Авах оноо
1.	Патент, зохиогчийн эрх: - Патент авсан бол - Зохиогчийн эрх авсан бол - Ашигтай загварын гэрчилгээ авсан бол	+10 +8 +5
2.	Шинжлэх ухаанд оруулж буй бодит хувь нэмэр: - Батлан хамгаалах салбарын өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн бол - Гадаад хэл дээр (гадаадад) бүтээл нь орчуулагдсан буюу хэвлэгдсэн бол - Сургалтад зориулагдсан бол	+10 +7 +4
3.	Хэвлэгдсэн байдал: - 500 ширхэг, түүнээс дээс хэвлэсэн - 200 ширхэг, түүнээс дээш хэвлэсэн - 50 ширхэг, түүнээс дээш хэвлэсэн - Зөвхөн шалгаруулалтад зориулж хэвлэсэн	+10 +5 +3 +1
4.	Бүтээлийн бичилт, зохион байгуулалт, агуулгын чанар: - Бүтээл, судалгааны үр дүн нь бодлого, үйл ажиллагаанд хэрэглэгдсэн бол - Онолын асуудлыг авч үзсэн - Практик асуудлыг авч үзсэн	+10 +7 +3
5.	Сэдвийн судлагдсан байдал: - Бүрэн судлагдсан - Дутуу судлагдсан - Судлагдаагүй	+10 +6 +2
6.	Бүтээлийн дүгнэлт, утга санааны ойлгомжтой байдал: - Утга санаа нь бүрэн илэрхийлэгдсэн - Гол санаа нь илэрхийлэгдэж гарсан - Агуулга, утга санаа нь дутуу илэрхийлэгдсэн бол	+10 +7 +4
7.	Шинэлэг байдал болон ашиглагдаж буй нотолгоо, жишээний оновчтой байдал: - Өмнө нь судлагдаагүй асуудлыг хөндсөн - Өмнө нь судлагдсан боловч шинэ шийдэл санал болгосон - Нотолгоо, жишээ оновчтой боловч шинэлэг бус бол	+10 +7 +4
8.	Бүтээлийн үзэмж, хэвлэлийн чанар, дизайн:	

	<ul style="list-style-type: none"> - Маш сайн - Сайн - Дунд 	<ul style="list-style-type: none"> +10 +7 +3
9.	Бүтээлийн өгүүлбэр зүй, бичилт: <ul style="list-style-type: none"> - Маш сайн - Сайн - Дунд 	<ul style="list-style-type: none"> +10 +5 +3
10.	Номын санд тавигдсан байдал: <ul style="list-style-type: none"> - 2 жилээс доошгүй - 6 сараас доошгүй - Тавигдаагүй бол 	<ul style="list-style-type: none"> +10 +6 +1
Нийт оноо		(25-100 оноо)

4.6.2. цэргийн зэвсэглэл, техник, инновацын дэвшлийн чиглэлээр хийгдсэн бүтээл:

№	Үзүүлэлт	Авах оноо
1.	Оюуны өмчийн гэрчилгээ, патент, ашигтай загварын гэрчилгээ: <ul style="list-style-type: none"> - Патент авсан бол - Зохиогчийн эрх авсан бол - Ашигтай загварын гэрчилгээ авсан бол 	<ul style="list-style-type: none"> +10 +8 +5
2.	Шинжлэх ухаанд оруулж буй бодит хувь нэмэр: <ul style="list-style-type: none"> - Батлан хамгаалах салбарын өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн бол - Анги, байгууллагын өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн бол - Сургалтад тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн бол 	<ul style="list-style-type: none"> +10 +7 +4
3.	Яамны ШУТЗ-ийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн /танилцуулсан/: <ul style="list-style-type: none"> - Хэлэлцүүлж дүгнэлт гаргуулсан бол - Танилцуулсан бол - Хэлэлцүүлээгүй бол 	<ul style="list-style-type: none"> +10 +5 +3
4.	Цэргийн хэрэгт нэвтрүүлэх боломж, практик хэрэглээ болгосон байдал, үр дүн: <ul style="list-style-type: none"> - Маш сайн - Сайн - Дунд 	<ul style="list-style-type: none"> +10 +7 +3
5.	Техникийн зурагтай эсэх: <ul style="list-style-type: none"> - Бүрэн хийгдсэн - Дутуу хийгдсэн - Хийгдээгүй 	<ul style="list-style-type: none"> +10 +6 +2
6.	Техник-эдийн засгийн үндэслэл, үр ашгийн тооцоо: <ul style="list-style-type: none"> - Маш сайн - Сайн - Дунд 	<ul style="list-style-type: none"> +10 +7 +4
7.	Бүтээлийн талаар хэвлэн нийтлүүлсэн байдал: <ul style="list-style-type: none"> - Өмнө нь судлагдаагүй асуудлыг хөндсөн - Өмнө нь судлагдсан боловч шинэ шийдэл санал болгосон - Нотолгоо, жишээ оновчтой боловч шинэлэг бус бол 	<ul style="list-style-type: none"> +10 +7 +4

8.	Бүтээлийн үзэмж, чанар, аюулгүй байдал, дизайн: - Маш сайн - Сайн - Дунд	+10 +7 +3
9.	Бүтээлийн бат бөх байдал : - Маш сайн - Сайн - Дунд	+10 +5 +3
10.	Туршигдсан байдал: - 2 жилээс доошгүй - 6 сараас доошгүй - Тавигдаагүй бол	+10 +6 +4
Нийт оноо		(35-100 оноо)

4.6.3. технологийн дэвшил чиглэлийн бүтээл:

№	Үзүүлэлт	Авах оноо
1.	Оюуны өмчийн гэрчилгээ, патент, ашигтай загварын гэрчилгээ: - Патент авсан бол - Зохиогчийн эрх авсан бол - Ашигтай загварын гэрчилгээ авсан бол	+10 +8 +5
2.	Өмнөх шийдлээс онцгой ялгарах шинж чанар: - Маш сайн - Сайн - Дунд	+10 +7 +4
3.	Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогод нийцсэн байх - Бүрэн нийцсэн - Нийцсэн - Нийцээгүй	+10 +5 +3
4.	Технологийг ашигласны эдийн засгийн үзүүлэлт: - Маш сайн - Сайн - Дунд	+10 +7 +3
5.	Технологийн карттай эсэх: - Бүрэн хийгдсэн - Дутуу хийгдсэн - Бүрэн хийгдээгүй	+10 +6 +2
6.	Бүтээгдэхүүний стандарт, чанар, аюулгүй байдал: - Бүрэн хангагдсан - Бүрэн хангагдаагүй - Стандарт хангаагүй	+10 +7 +4
7.	Яамны ШУТЗ-ийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн /танилцуулсан/: - Хэлэлцүүлж дүгнэлт гаргуулсан бол - Танилцуулсан бол - Хэлэлцүүлээгүй бол	+10 +7 +4
8.	Туршигдсан байдал:	

	<ul style="list-style-type: none"> - Маш сайн - Сайн - Дунд 	<p>+10 +7 +3</p>
9.	<p>Эдийн засгийн болон нийгмийн ач холбогдол:</p> <ul style="list-style-type: none"> - Маш сайн - Сайн - Дунд 	<p>+10 +5 +3</p>
10.	<p>Танилцуулгын өгүүлбэр зүй, утга найруулга:</p> <ul style="list-style-type: none"> - Маш сайн - Сайн - Дунд 	<p>+10 +6 +4</p>
Нийт оноо		(35-100 оноо)

4.6.4. 35 хүртэлх насны залуу судлаачийн бүтээл:

№	Үзүүлэлт	Авах оноо
1.	<p>Оюуны өмчийн гэрчилгээ, патент, ашигтай загварын гэрчилгээ:</p> <ul style="list-style-type: none"> - Патент авсан бол - Зохиогчийн эрх авсан бол - Ашигтай загварын гэрчилгээ авсан бол 	<p>+10 +8 +5</p>
2.	<p>Шинжлэх ухаанд оруулж буй бодит хувь нэмэр:</p> <ul style="list-style-type: none"> - Батлан хамгаалах салбарын өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн бол - Анги, байгууллагын өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн бол - Сургалтад тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн бол 	<p>+10 +7 +4</p>
3.	<p>Бүтээлийн онол, аргазүйн түвшин</p> <ul style="list-style-type: none"> - Маш сайн - Сайн - Дунд 	<p>+10 +5 +3</p>
4.	<p>Бүтээлийн эзэн залуу судлаач нь:</p> <ul style="list-style-type: none"> - Докторын зэрэг хамгаалсан бол - Магистрын зэрэг хамгаалсан бол - Бакалаврын зэрэг хүртэл зэрэгтэй бол 	<p>+10 +7 +3</p>
5.	<p>Бүтээлийн судалгааны эргэлтэд орсон байдал:</p> <ul style="list-style-type: none"> - Олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэгдсэн бол - Салбарын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэгдсэн бол - Сургууль, тэнхимийн эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэгдсэн бол 	<p>+10 +6 +2</p>
6.	<p>Бүтээлийн цэргийн хэрэг, үйлдвэрлэл, практикийн ач холбогдол:</p> <ul style="list-style-type: none"> - Маш сайн - Сайн - Дунд 	<p>+10 +7 +4</p>
7.	<p>Шинэлэг байдал болон ашиглагдаж буй нотолгоо, жишээний оновчтой байдал:</p> <ul style="list-style-type: none"> - Өмнө нь судлагдаагүй асуудлыг хөндсөн - Өмнө нь судлагдсан боловч шинэ шийдэл санал 	<p>+10 +7</p>

	болгосон - Нотолгоо, жишээ оновчтой боловч шинэлэг бус бол	+4
8.	Бүтээлийн үзэмж, чанар, дизайн: - Маш сайн - Сайн - Дунд	+10 +7 +3
9.	Бүтээлийн танилцуулгын өгүүлбэр зүй, бичилт: - Маш сайн - Сайн - Дунд	+10 +5 +3
10.	Бүтээлийн боловсруулалтын түвшин (техник, технологийн шийдэл, бат бөх, аюулгүй байдал): - Маш сайн - Сайн - Дунд	+10 +6 +4
Нийт оноо		(35-100 оноо)

4.6.5. шинэ бүтээл, оновчтой саналын бүтээл:

№	Үзүүлэлт	Авах оноо
1.	Оюуны өмчийн гэрчилгээ, патент, ашигтай загварын гэрчилгээ: - Патент авсан бол - Зохиогчийн эрх авсан бол - Ашигтай загварын гэрчилгээ авсан бол	+10 +8 +5
2.	Өмнөх шийдлээс онцгой ялгарах шинж чанар: - Маш сайн - Сайн - Дунд	+10 +7 +4
3.	Шинэ бүтээлийн тодорхойлолт, томъёолол, товч тайлбар, холбогдох зураг: - Маш сайн - Сайн - Дунд	+10 +5 +3
4.	Олон улсын болон үндэсний стандартыг хангасан байдал: - Маш сайн - Сайн - Дунд	+10 +7 +3
5.	Техникийн зураг, технологийн карттай эсэх: - Бүрэн хийгдсэн - Дутуу хийгдсэн - Судлагдаагүй	+10 +6 +2
6.	Техник-эдийн засгийн үндэслэл, үр ашгийн тооцоо: - Маш сайн - Сайн - Дунд	+10 +7 +4
7.	Шинэлэг байдал болон ашиглагдаж буй нотолгоо, жишээний оновчтой байдал: - Өмнө нь судлагдаагүй асуудлыг хөндсөн	+10

	- Өмнө нь судлагдсан боловч шинэ шийдэл санал болгосон	+7
	- Нотолгоо, жишээ оновчтой боловч шинэлэг бус бол	+4
8.	Бүтээлийн үзэмж, чанар байдал, дизайн: - Маш сайн - Сайн - Дунд	+10 +7 +3
9.	Бүтээлийн танилцуулгын өгүүлбэр зүй, бичилт: - Маш сайн - Сайн - Дунд	+10 +5 +3
10.	Бүтээлийн боловсруулалтын түвшин, найруулга зүй, оновчтой хэллэг, зөв бичлэг (техник, технологийн шийдэл, соёл): - Маш сайн - Сайн - Дунд	+10 +6 +4
Нийт оноо		(35-100 оноо)

Тав. Шилдэг бүтээлийг шалгаруулж, дүнг гаргах

5.1. Комисс бүтээлийн төрөл тус бүрд үнэлгээ (оноо) өгч, хамгийн өндөр үнэлгээ (оноо) авсан бүтээлүүдийг яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хуралдаанд танилцуулна.

5.2. Яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөл нь комиссын гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэж, шийдвэр гаргана.

5.3. Зөвлөлийн гишүүний бүтээл нэр дэвшсэн тохиолдолд зохиогч санал өгөхгүй.

5.4. Зөвлөлийн гишүүд нь ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж шаардлагатай тохиолдолд санал өгөхөөс татгалзах эрхтэй.

5.5. Яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хуралдааны шийдвэрийг Батлан хамгаалахын сайдад танилцуулж, дүнг сайдын тушаалаар баталгаажуулна.

**БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨЛ**